



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 03 сарын 10 өдөр

Дугаар А/132

Чингис хот

Урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, Улсын Онцгой комиссын №07 дугаар хурлын тэмдэглэл, аймгийн Онцгой комиссын №06 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх зорилгоор Улаанбаатар хот болон голомтод бүс нутгаас хүндэтгэн үзэх шалтгаан /албан томилолт, эрүүл мэнд, ар гэрийн гачигдал, хүнс тээвэр/-аас бусад иргэдийн орох хөдөлгөөнийг 2021 оны 3 дугаар сарын 12-ны өдрийн 06:00 цагаас тодорхойгүй хугацаагаар хязгаарласугай.

2. Аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд элэн нийтийг хамарсан хурал, цуглаан, урлаг соёлын тоглолт, спортын уралдаан тэмцээний арга хэмжээ зохион байгуулахыг хориглосугай.

3. Орох хөдөлгөөнийг хязгаарласантай холбогдуулан Чингис хотын хаалганд шалган нэвтрүүлэх хяналтын цэг ажиллуулахыг Цагдаагийн газар /Б.Батсайхан/, Онцгой байдлын газар /Ж.Эрдэнэбат/, Мэргэжлийн хяналтын газар /Б.Сүнгээ/-т тус тус даалгасугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Ц.Чогсомжав/, Шуурхай штаб дарга /Ж.Эрдэнэбат/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА Ц.ИДЭРБАТ



231010369